

“ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ
/ЭХ НЯРАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ/

2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2025 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилт ийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр, сая төг		
Зорилго: Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих, иргэн бүрт эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх						
Зорилт 1. Эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжсэн тогтолцооны чиглэлээр бодлого, эрхзүйн орчинг сайжруулах						
1.1	Ажил мэргэжлийн ангилал, онцлогт тохирох дасгал хөдөлгөөний загварыг боловсруулж тасаг нэгжээр сурталчлах	Дасгал хөдөлгөөнийг олон нийтэд сурталчилсан байна	-	-	Жирэмсэн эхчүүдэд зориулсан дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийн ач холбогдол, жирэмсний хугацаанд болон төрсний дараа хийж болох дасгалуудын талаар мэдээлэл 7 төрлийн видео шторк бэлтгэн зурагт дэлгэцүүдээр хүргэж байна. Мөн амбулаторийн тусламж үйлчилгээ авч буй жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох 5 төрлийн 1500 ширхэг гарын авлага тарааж ажилласан. Ажлын байрны дасгал хөдөлгөөний тухай нийт 4 төрлийн сурталчилгааны материал боловсруулж нийт 14 тасгийн 416 албан хаагчдад тарааж нийт 35 удаа сурталчилгаа хийсэн. Мөн өөрийн фэйж хуудас болон бусад дүүргийн олон дагагчтай групп хуудаснууд дээр ажил мэргэжлийн онцлогт тохирсон дасгал хөдөлгөөний тухай мэдээ мэдээллийг нийт 21 удаа байршуулж нийт 14700 хүн хандалт хийсэн байна.	60
Зорилт 2. Эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжсэн дэд бүтцийг хүн амын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй болгох						
2.1	Хүн амын хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үзлэг,	Эрт илрүүлгийн төвийн үйл	-	-	2025 оны эхний 5 сарын байдлаар эрт илрүүлэг үзлэгийг нийт 1458 хүн хамрагдсан бөгөөд 75% нь иргэн, 25% нь албан байгууллагын ажилчид байсан. Үзлэгт хамрагдсан иргэдийн	

	оношилгоонд хамрагдах эрүүл мэндийг дэмжих эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах	ажиллагаа тогтмолжсон байна.	-	-	60% эмэгтэйчүүд 40% нь эрэгтэйчүүд байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 29% хувь нь хоол боловсруулах эрхтэний, 22% хувь нь амьсгалын замын эрхтэний, 19% хувьд нь бамбай булчирхайн эмгэг өөрчлөлт илэрсэн. Тус үйл ажиллагаа нь 9 төрлийн шинжилгээнд үйлчлүүлэгчдийг хамруулсан. Үүнд: - Зүрхний цахилгаан бичлэг - ЭХО (бамбай, хөх, элэг цөс, нойр булчирхай, хэвлий, түрүү булчирхай) - Цээжний рентген оношилгоо - ЦДШ, - ШЕШ, - Биохими, ДОХ, БЗДХӨ - Өтгөнд далд цус элрүүлэх, - Эсийн пап шинжилгээ - Уян дуран (улаан хоолой, ходоод) - Эрсдэлийн үнэлгээ Шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо: Нийт 1458 хүнд үзлэг, шинжилгээ хийснээс 1. Өөрчлөлттэй гарсан- 391 хүн 2. Хавсарсан өөрчлөлттэй гарсан– 562 хүн 3. Огт үзүүлээгүй - 6 хүн 4. Ходоодны дуранд хамрагдсан нийт- 343 хүн Үүнээс шинжилгээнд өөрчлөлттэй гарсан хүний тоо: 1. Зүрх судасны өвчтэй- 321 хүн 2. Уушгины өвчтэй- 142 хүн 3. Цөсний чулуутай , өтгөн, мэс заслаар авхуулсан, үрэвсэлтэй- 248 хүн 4. Нойр булчирхайн үрэвсэлтэй - 379 хүн 5. Бамбай булчирхайн өөрчлөлттэй - 589 хүн 6. Түрүү булчирхайн өөрчлөлттэй - 171 хүн 7. Эсийн шинжилгээ Пап тестээр өөрчлөлттэй - 11 8. Биеэнд агуулагдах липидийн хэмжээ алдагдсан - 179 хүн 9. Чихрийн шижинтэй - 52 хүн 10. Элэгний В.С вирустэй, үрэвсэлтэй- 48 хүн	60
--	---	------------------------------	---	---	---	----

					11. Бөөрний чулуутай, элсэнцэртэй- 74 хүн 12. Урагцаг, уйланхайтай- 54 хүн Дээрх шинжилгээнд өөрчлөлттэй гарсан үйлчлүүлэгчдийг хүн нэг бүрчлэн эрүүл амьдралын хэв маягийн талаархи зөвлөгөөг өгч, шаардлагатай тохиолдолд харьяаллын дагуу нарын мэргэжлийн эмч төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг рүү тус тус илгээж шийдвэрлэж байна. Хүүхдийн нарийн мэргэшлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгээр - Нийслэлийн СХД-н 188-р цэцэрлэгт 2025.05.07-08-ны өдөр бага, дунд , ахлах, бэлтгэл бүлгийн нийт 27 бүлгийн 630 хүүхдэд, зүрхний судасны эмч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зүрхний урьдчилан сэргийлэх үзлэгийг 23 хүүхдэд хийсэн байна. Үүнээс: 6.6% (42) нь өсөлтийн хоцрогдолтой, 54.7% (345) шүд эмчлүүлэх шаардлагатай, 7.1% (45) уруул болон хэлний хөвч богино Ерөнхий мэс заслын эмчийн үзлэг: Эрэгтэй хүүхдүүдэд тээрхийн арьсны нарийсал- 25, ахлах болон бэлтгэл ангийн хүүхдүүдэд ШЕШ , шимэгч хорхойн шинжилгээ өгөхөд 7 хүүхдэд шимэгч хорхой эерэг +/- гарсан. Үзлэгээр илэрсэн өөрчлөлт бүрийг тухайн хүүхдэд болон багш, сургуулийн эмчид тухай бүрд нь тайлбарлан зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Цаашид урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөөг хүүхэд бүрд өгөв. Эмийн эмчилгээ хийлгэх шаардлагатай хүүхдүүдээ эмийн эмчилгээ цаг тухай бүрд нь бичиж өгсөн.	
2.2	Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын веб сайтад “ Эмч зөвлөж байна” линк үүсгэн эмч нарын зөвлөгөө, шинэ дэвшилтэт технологи, асран хамгаалагчдад	Веб сайтад “ Эмч зөвлөж байна” линк үүсгэн тогтмолжиж, иргэдийн санал хүсэлтийн	-	-	Төвийн фейсбүүк пейж хуудсанд 31 постер мэдээлэл, нэг видео зөвлөмж, Веб хуудасны “ Эмч зөвлөж байна” буланд эмч нарын зөвлөмж ярилцлага 2, постер мэдээлэл 12-ыг байршуулан иргэдэд зөвлөмж мэдээллийг хүргэж тогтмолжуулсан байна. Сургалтыг нийт 7 удаа зохион байгуулж нийт 920 хүн, сурталчилгааг 32 удаа зохион байгуулж 9800 гаруй хүн хамруулж нийт 3200 ширхэг сурталчилгааны материал тараасан байна. Сурталчилгааны нөлөөллийн цуврал	70

	зориулсан мэдээлэл, яриа лекцийг тогтмол тавьж ажиллуулах	мэдээний сан үүссэн байна.			мэдээллийг сар бүрийн давтамжтайгаар 6 удаа шинэчлэн байршуулсан. ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 31250 хүн хандалт хийсэн.	
Зорилт 3. Эрүүл, идэвхтэй хөдөлгөөнийг эрхэмлэх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэх						
3.1	Эхийн сүүгээр дагнан хооллох зан үйлийг төлөвшүүлэх санамж, зурагт хуудас, ТВ шторк, сургалтыг зохион байгуулах	Нийгмийн сүлжээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхээс гадна, сургалт зохион байгуулсан байна.	-	-	Хөхний сүүний донор банк байгуулах ажлын бэлтгэл ажил ханган ажиллаж байна. Үүнд: ➤ Эмч мэргэжилтнийг сургалтад хамруулсан. ➤ Хөхний сүү хадгалах гүн хөргүүр суурилуулсан. ➤ Хөхний сүү хадгалах уут, хөхний сүү саах гар болон цахилгаан саалтуур бэлтгэсэн. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/290 дүгээр тушаалаар батлагдсан Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “10 алхам”-ыг хэрэгжүүлэн дараах ажлыг хийсэн. Эхчүүдэд хөхний хэлбэртэй муляжаар бодитоор үзүүлэн хөхөөр хооллолтын ач холбогдол, хүүхдээ хэрхэн зөв хөхүүлэх талаарх сургалтыг сар бүр хийж хагас жилийн байдлаар 1680 эхийг хамруулсан байна. Хөхөөр хооллолтын ач тус, хэрхэн зөв хөхүүлэх талаарх танилцуулга бэлтгэн төрсний дараах тасагт байршуулсан. “Эхийн сүүгээр хооллох 10 алхам” сургалтыг 2025.05.13-ны өдөр зохион байгуулж нийт 69 эх баригч, сувилагч нар хамрагдсан.	70

					Төрсний дараах тасагт хэвтэн эмчлүүлж буй эхчүүдэд хүүхдийг хөхөөр хооллолтын ач холбогдол, зөв хөхүүлэх арга болон эхийн хөх арчилгааны талаар ЭМБОС-ыг эх баригч, бага мэргэжилтнүүд тогтмол хийж байна. Мөн хэвтэн эмчлүүлж буй эхчүүдэд ангир уураг, эхийн сүүний ач холбогдлын талаар олон талт мэдээлэл багтаасан зөвлөмж, 32 ширхэг гарын авлага бэлтгэн хүргэж байна. Нийт 9 удаа сургалт зохион байгуулж 540 хүн, 19 удаа сурталчилгаа зохион байгуулж нийт 1700 хүн хамруулж 1500 ширхэг сурталчилгааны материал тараасан байна. Төвийн мэдээлэл хүргэх зурагт дэлгэцүүдээр өдөр бүр 3 төрлийн мэдээлэл иргэдэд хүргэж байна. Мөн өөрийн фэйж хуудас болон бусад дүүргийн олон дагагчтай групп хуудсууд дээр эхийн сүүний тухай мэдээ мэдээллийг нийт 15 удаа байршуулж нийт 8100 хүн хандалт хийсэн байна.	
3.2	Хүн амын насны бүлэг, өвөрмөц бүлэг бүрт тохирсон зохистой хооллолтын зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	Нийгмийн сүлжээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байна.	-	-	Сурталчилгааны нөлөөллийн цуврал мэдээллийг сар бүрийн давтамжтайгаар 6 удаа шинэчлэн байршуулсан. ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 31250 хүн хандалт хийсэн. Төвийн жирэмсний хяналтанд эхчүүдэд жирэмсэн үед шаардлагатай амин дэм, зөв хооллолт болон жирэмсний үед хориглох хоол хүнсний талаар мэдээлэл бэлтгэн 122 ээжид гарын авлага хүргэсэн. Мөн эрүүл зохистой хооллолт ба хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага бэлтгэн тараасан. Атар-Өргөө, ХУД-ын Замын	65

				цагдаагийн газар, Архивын Ерөнхий газар, Номин ХХК, ХУД 21-р хороо зэрэг төр болон хувийн хэвшил, ААНБ-уудтай хамтран нийт 4 удаа “Зөв зохистой хооллолт, дасгал хөдөлгөөн” сэдвээр сургалт зохион байгуулж нийт 670 ажилтан, 350 иргэн хамруулсан байна. Нийт 21 удаа зохистой хооллолт, дасгал хөдөлгөөн, чихрийн шижин өвчтэй хүний хооллолт, зүрх судасны өвчний үеийн хооллолт зэрэг сэдвүүдээр сурталчилгаа зохион байгуулж нийт 4100 хүн хамруулж 2000 ширхэг 4 төрлийн сурталчилгааны материал тараасан байна. 2025 оны эхний хагас жилд Амбулаторын тусламж үйлчилгээ авч буй нийт үйлчлүүлэгчдэд 1 сарын хугацаатай Хүн амын насны бүлэг, өвөрмөц бүлэг бүрт тохирсон зохистой хооллолтын талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлох судалгааг хийх, дата цуглуулж боловсруулалт хийсэн. Нийт судалгаанд оролцсон 1132 хүнээс дасгал хийдэг эсэхийг нь тодорлуулахад ихэнх нь буюу 67,4% нь хийдэггүй, 32,6% нь хийдэг гэж хариулсан байна. Судалгааны дүгнэлт: Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 10 хүний 4 нь Чихрийн шижингийн эрсдэлтэй, мөн артерийн даралт ихтэй, 4 хүний 3 нь жингийн илүүдэлтэй байна. Төвийн таргалалтаар авч үзвэл эрэгтэйчүүдийн 10 хүний 7 нь, эмэгтэйгчүүдийн 10 хүний 8 нь төвийн таргалалттай буюу ХАӨ-тэй болох эрсдэл маш өндөр байна. Мөн хөдөлгөөний идэвхийг нь авч үзвэл ихэнх нь буюу 10 хүний 7 нь дасгал хөдөлгөөн огт хийдэггүй гэж хариулсан нь таргалалт болон төвийн таргалалттай хүний тоо өндөр байгаатай холбоотой байж болох юм. Хооллох зуршлыг судалсан дүнгээс харахад 33% нь өглөөний цайгаа тогтмол уудаггүй, 34% нь хоолоо хурдан иддэг, 60% нь хоолоо ижил хэмжээтэй идэж заншаагүй байна. Хоол шим тэжээлийн байдлаар авч үзвэл 70% нь зохистой хооллож чаддаггүй бөгөөд үүний гол шалгаан нь давс, элсэн чихэр агуулсан бүтээгдэхүүний хэрэглээ өндөр, жимс, хүнсний ногооны хэрэглээ бага байгаатай холбоотой. Хоол шим тэжээлийн боловсрол олгох төвөөр	
--	--	--	--	--	--

					үйлчлүүлсэн нийт 1304 иргэнээс 254 хүн ЧШӨ-өөр, 635 хүн жингийн илүүдэлтэйгээ, 303 хүн Артерийн даралт ихсэх өвчнөөр тус анх оношлогдсон байна. Эдгээргээс харахад эрүүл амьдралын хэв маягт сургах ажлыг өргөн цар хүрээтэй хийж урьдчилан сэргийлэх кабенитуудыг тоог нэмэх шаардлагатай байна.	
3.3	Хүнсний бүтээгдэхүүний шошгын мэдээллийг ашиглан эрүүл хүнс сонгон хэрэглэх, давсны хэрэглээг бууруулах сурталчилгаа хийх	Нийгмийн сүлжээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байна.	-	-	Ундны ус, хүнсний аюулгүй байдлын хадгалалт, эрүүл ус хүнс хэрэглэх заавар постер мэдээлэл дараах пейж хуудас веб сайтаар: ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 29710 хүн хандалт хийсэн. Эрүүл хүнс сонгох, давсны хэрэглээг бууруулах талаарх сурталчилгааг төвөөр үйлчлүүлж буй иргэд, хэвтэн эмчлүүлэгч нарт нийт 11 удаа сурталчилгаа хийж 2500 хүн хамруулсан.Нийт 2 төрлийн 1500 ширхэг сурталчилгааны гарын авлага тараасан.	60
Зорилт 4. Сэтгэц, зан үйл, танин мэдэхүйн эрүүл мэндийг дэмжсэн нийгмийн орчинг бүрдүүлэх						
4.1	Архи, тамхинаас татгалзах сэдлийг дэмжих ухуулга нөлөөллийн сурталчилгаа хийх	Нийгмийн сүлжээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр	-	-	Архи, тамхи, мансууруулах бодисны хэрэглээг судалснаар түүний хор уршгаас урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллахад чухал нөлөө үзүүлнэ.Нийт судалгаанд хамрагдсан 58 иргэдийн 56,8% (33) нь эрэгтэй, 43,2% (25) эмэгтэйчүүд оролцсон байна. ДҮГНЭЛТ:	65

		сурталчилсан байна.			Судалгаанд оролцогчдын архи, тамхи мансууруулах бодисыг хэрэглээ өндөр байна. Өсвөр үе залуучуудын дунд ойр дотны хүн, найз нөхдийн архи, тамхины хэрэглээний хувь 40- дээш насныханы судалгаа хэрэглээ өндөрөөр ижил боловч мансууруулах бодис тамхи, архины хэрэглээ нь өөр гарч байна. Иймд дараах ажлуудыг зохион байгуулсан. Төвийн мэдээлэл хүргэх зурагт дэлгэцүүдээр архи согтууруулах ундаа түүний сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээлэл бэлтгэн олон удаагийн давтамжтай хүргэж байна. Хүүхдийг дам тамхидалтаас урьдчилан сэргийлэх зөвлөмж постер мэдээллийг төвийн цахим хуудсаар дамжуулан хүргэж 3500 хүний хандалт авсан байна. Мөн төвийн тасаг нэгжүүдээр тамхи татахыг хориглосон зурагт хуудсуудыг байршуулсан байна. 21 дүгээр хорооны архины хамааралтай 14 эмэгтэй 8 эрэгтэй нийт 22 хүний шинжилгээ, үзлэгт хамрагдсан. Архи, тамхинаас татгалзах сэдлийг дэмжих ухуулга нөлөөллийн сурталчилгааг ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 31900 хүн хандалт хийсэн.	
4.2	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх	Нийгмийн сүлжээ хэвлэл	-	-	Өсвөр насныхныг сонсьё, ойлгоё аяны хүрээнд тус Төвийн сургалтын алба, эмч эмнэлгийн мэргэжилтнүүд ХУД-ийн 114-р сургуулийн 10-р ангийн 120 гаруй сурагчдад “Өсвөр насны сэтгэл зүйн онцлог”, “Бие махбодид гарах өөрчлөлт, бэлгийн боловсрол”, “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх”	


	ташаа ойлголт хандлагыг өөрчлөх сурталчилгаа хийх	мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна.			сэдвүүдээр мэдээлэл хийж өсвөр үеийн Сурагчдын сонирхсон асуултанд эмч мэргэжилтнүүд хариулт өгч, нээлттэй чөлөөтэй ярилцан үр өгөөжтэй сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг тус сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар хамтран зохион байгуулсан. Өөрийн пэйж хуудсаар дамжуулан нийт 22 удаагийн давтамжтай 9 төрлийн мэдээллийг байршуулж 6000 хүн хандалт хийсэн байна. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг ойлгох, хамгаалах сэдвээр нийт 17 удаа сурталчилгаа хийж нийт 3500 хүн хамруулж 1500 ширхэг сурталчилгааны материал тараасан. Дауны өдөр, аутизмыг ойлгох өдөр зэрэг дэлхийн өдрүүдийг угтан өөрийн пэйж хуудас болон бусад дүүргийн олон дагагчтай групп хуудсууд дээр “Тэднийг ойлгоё, хүндлэе”, “Даунтай болон аутизмтай хүүхдүүдийг ойлгоё, тэднийг хамгаалай” сэдвээр мэдээ мэдээллийг нийт 12 удаа байршуулж нийт 17800 хүн хандалт хийсэн байна.	70
Нэгдсэн дүгнэлт		Арга хэмжээний биелэлтийг гаргаж хүргүүлсэн байна.	-	-	Тус арга хэмжээний хүрээнд 4 зорилт 8 үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэн 75 хувийн биелэлттэй ажилласан байна. Тус зорилтын хүрээнд нийт 2 өдөрлөг зохион байгуулж нийт 250 хүн, нийт 12 удаагийн сургалтаар 950 хүн, 37 удаагийн сурталчилгаа хийж 21800 хүн хамруулж 2500 ширхэг 4 төрлийн сурталчилгааны гарын авлага боловсруулан иргэдэд тарааж эрүүл идэхитэй амьдралын тухай олон нийтэд хүргэж ажилласан. Мөн төрийн 2 байгууллага, төрийн бус 2 байгууллага, 5 ААНБ-уудтай хамтран нийт 2 удаа сурталчилгаа зохион байгуулж нийт 540 ажилчид хамруулан ажилласан байна. Өөрийн фэйж хуудас болон бусад дүүргийн олон дагагчтай групп хуудсууд дээр ажил мэргэжлийн онцлогт тохирсон дасгал хөдөлгөөний тухай мэдээ мэдээллийг нийт 21 удаа байршуулж нийт 31900 хүн хандалт хийсэн байна. Веб хуудасны “Эмч зөвлөж байна” буланд эмч нарын зөвлөмж ярилцлага 2, постер мэдээлэл 12-ыг байршуулан иргэдэд зөвлөмж мэдээллийг хүргэж тогтмолжуулсан байна.	75

Хавсралт



Төвийн жирэмсний хяналтанд байдаг эхчүүдэд “ Жирэмсний үеийн дасгал хөдөлгөөн”, “ Жирэмсэн үед тохиромжтой дасгал хөдөлгөөнүүд”-ийн талаар сурталчилгаа хийж буй байдал:



Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг хувь хүн, албан байгууллага, сургууль, цэцэрлэгийн хүрээнд зохион байгуулж буй нь:



Төвийн фейсбүүк пейж хуудас, веб сайтны “Эмч зөвлөж байна” булан болон төвийн мэдээлэл хүргэх зурагт дэлгэцүүдээр дамжуулан постер болон видео зөвлөмжүүдийг хүргэж буй нь:



Иргэдэд гарын авлага, сурталчилгааны материал тарааж буй байдал:



Тасгуудад хэвтэн эмчлүүлж буй эхчдүүдэд хуваарийн дагуу эхийн сүүгээр хооллолтын сургалтуудыг орж, зөвлөмж тараах материал хүргэж буй байдал:



Сэтгэлзүйн эрүүл мэндэд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа хийсэн нь:

